

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Чандмань-Увс” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2025 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Амармэнд
Утас: 70453721, Цахим хаяг: Amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
“ЧАНДМАНЬ-УВС” ХХК-ийн ЗАХИРАЛ
Б.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

2026. 03. 13 № УВА-2026/002/НА-СТА-ОНДУГ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК-ийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/46 дугаар тушаалаар компанийн шинэ жилийн баярын цэнгүүний үйл ажиллагаанд зориулан 6,785.0 мянга, 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр цэвэрлэх байгууламжийн Улаанбаатар хотоос ирсэн хүмүүст зориулж согтууруулах ундаа худалдан авахад 340.0 мянган төгрөгийг компанийн төсвөөс зарцуулсан, захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар нэг албан хаагчид ногдуулсан сахилгын шийтгэл 810.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй, захирлын 2025 оны А/07, А/11, А/17, А/44 дүгээр тушаалуудаар тэмцээн уралдаан болон шинэ жилийн бэлэг өгөхөд компанийн төсвөөс 6,197.8 мянган төгрөгийг зарцуулсан, Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 575,885.4 мянган төгрөгийн 44 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 132,900.1 мянган төгрөгийн 45 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 811,327.6 мянган төгрөгийн 52 зарлагын мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроон байршуулсан, 2025 онд 16 ажилтанд олгосон 23,845.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг тайлант хугацаанд суутган тооцоогүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь заалтад “Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, Төрийн хэмнэлтийн тухай

8525050741

хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.1.7 дахь заалтад “Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах”, 15.1.8 дахь заалтад “Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын 1.3-д “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж, төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	363,923,161.98	301,435,808.83
1.1.02	Дансны авлага	79,690,571.99	177,008,563.60
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	159,002.03
1.1.06	Бараа материал	150,000,613.37	160,183,062.56
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	30,600,000.00	1,000,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	624,214,347.34	639,786,437.02
1.2.01	Үндсэн хөрөнгө	6,749,122,114.39	8,456,301,243.46
1.2.02	Биет бус хөрөнгө	1,641,168,500.19	1,632,920,500.00
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	200,000.00	200,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,390,490,614.58	10,089,421,743.46
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,014,704,961.92	10,729,208,180.48
2.1.1.01	Дансны өглөг	104,337,126.03	140,375,920.60
2.1.1.03	Татварын өр	45,790,888.58	42,324,090.49
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	150,128,014.61	182,700,011.09
2.1.2.01	Урт хугацаат зээл	795,668,200.00	795,668,200.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	795,668,200.00	795,668,200.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	945,796,214.61	978,368,211.09
2.3.02	- хувийн	7,891,328,653.58	9,832,947,301.18
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	500,496,180.38	500,496,180.38
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	1,635,344,266.34	1,635,344,266.34
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-1,958,260,352.99	-2,217,947,778.51
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-259,687,425.52
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-1,958,260,352.99	-1,958,260,352.99
2.3.11	Эздийн өмчийн дүн	8,068,908,747.31	9,750,839,969.39
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,014,704,961.92	10,729,208,180.48

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	2,336,974,624.03	2,865,558,272.22
02	Борлуулалтын өртөг	1,993,127,381.54	2,411,761,980.40
03	Нийт ашиг(алдагдал)	343,847,242.49	453,796,291.82
10	Ерөнхий ба удирдлагын зардал	367,705,655.32	539,160,138.91
12.1	Зардлын дүн	367,705,655.32	539,160,138.91
17	Бусад ашиг (алдагдал)	-94,714,906.11	-174,323,578.43
17.1	Олз, гарзын дүн	-94,714,906.11	-174,323,578.43
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-118,573,318.94	-259,687,425.52
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-118,573,318.94	-259,687,425.52
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-118,573,318.94	-259,687,425.52

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2024 оны 01 сарын 01-нээрх үлдэгдэл	7,450,598,823.58	500,496,180.38	1,619,316,571.41	-1,839,687,034.05	7,730,724,541.32
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-118,573,318.94	-118,573,318.94
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	440,729,830.00	0.00	16,027,694.93	0.00	456,757,524.93
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
09	2024 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	7,891,328,653.58	500,496,180.38	1,635,344,266.34	-1,958,260,352.99	8,068,908,747.31
10	2025 оны 01 сарын 01-нээрх үлдэгдэл	7,891,328,653.58	500,496,180.38	1,635,344,266.34	-1,958,260,352.99	8,068,908,747.31
11	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-259,687,425.52	-259,687,425.52
14	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Өмчид гарсан өөрчлөлт	1,941,618,647.60	0.00	0.00	0.00	1,941,618,647.60
16	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
18	2025 оны 12 сарын 31-р нээрх үлдэгдэл	9,832,947,301.18	500,496,180.38	1,635,344,266.34	-2,217,947,778.51	9,750,839,969.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,641,579,461.07	3,118,132,878.01
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,466,756,131.27	2,989,140,187.18
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	39,716.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	95,155,239.51	99,313,421.62
1.1.6	Бусад мөнгөн орлого	79,628,374.29	29,679,269.21
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,297,812,940.09	2,874,588,055.14
1.2.1	Ажиллагчдад төлсөн	931,760,697.03	1,261,390,116.81
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	269,600,776.00	380,458,186.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	14,691,920.00	237,520.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	317,309,214.16	521,235,971.10
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	345,368,192.27	306,581,592.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	111.19	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	386,021,482.64	387,440,916.45
1.2.9	Бусад мөнгөн зарлага	33,060,546.80	17,243,752.78
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	343,766,520.98	243,544,822.87
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	239,838.41	1,322,346.98
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	239,838.41	1,322,346.98
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	93,759,520.00	307,354,523.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	65,049,520.00	307,354,523.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,710,000.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-93,519,681.59	-306,032,176.02
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	250,246,839.39	-62,487,353.15
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	113,676,322.59	363,923,161.98
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	363,923,161.98	301,435,808.83

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтод түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	2024 он	2025 он	
		Гүйцэтгэл /мян.төг/	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/
1	Цалин	1,031,139.90	1,477,026.00	1,384,420.92
2	НДШ, ЭМДШ	143,811.10	215,404.92	200,602.40
3	Хоолны хөнгөлөлт	31,319.00	118,566.00	100,040.40
4	Түлш нүүрсний хөнгөлөлт	11,950.00	22,680.00	21,600.00
5	Цахилгаан эрчим хүч	112,481.90	208,608.00	213,820.61
6	Дулаан	43,597.50	45,883.20	38,337.40
7	Түлш нүүрс	30,208.80	29,400.00	17,623.00
8	Бензин шатахуун	84,472.40	65,462.04	51,346.30
9	Сэлбэг хэрэгсэл	35,650.50	27,580.00	26,434.10
10	Материал түүхий эд	163,663.00	118,979.97	101,185.00
11	Ариутгал халдваргүйжүүлэлт	240.00	500.00	150.00
12	Томилолтын зардал	15,458.90	45,520.00	26,033.80
13	Холбоо, бичиг хэрэг, хэвлэл захиалга	5,700.70	24,183.60	25,095.80
14	Старлинк интернэт		5,000.00	-
15	Сургалтын зардал	8,560.00	16,904.00	10,025.00
16	Хөдөлмөр хамгаалал	33,299.70	53,983.80	69,060.50
17	Зар сурталчилгааны зардал	4,100.00	6,000.00	5,350.00
18	Ус шинжилгээний зардал	2,191.00	4,800.00	2,100.00
19	Лабораторын бодис устгах зардал		7,500.00	5,526.40
20	Т.У.З-ийн зардал	18,515.80	42,675.20	34,900.60
21	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	454,320.40	489,150.00	543,541.77
22	Зохицуулах үйлчилгээний хөлс	8,930.00	11,000.00	14,295.20
23	Граж түрээсийн зардал	7,000.00	5,000.00	8,200.00
24	Аудитын хөлс	5,280.00	5,280.00	5,280.00
25	Тээврийн хэрэгслийн татвар, агаарын бохирдолын татвар, оношлогоо	795.10	1,084.60	777.90
26	Газрын татвар	13,629.60	14,500.00	12,586.39
27	Бууны татвар	60.00	60.00	60.00
28	Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,465.40	10,000.00	8,465.55
29	Ус бохирдуулсны татвар	-	500.00	-
30	Гишүүн байгууллагын татварууд	3,570.00	2,700.00	2,620.00
31	Хөрөнгө, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгал,	8,471.20	6,500.00	8,293.10
32	Ажлын хөлс, тээврийн хөлс, үйлчилгээний хөлс	55,068.80	20,000.00	15,617.80
33	Кибер аюулгүй байдлын зардал		15,000.00	-
34	Гамшгийн эрсдэлийн зардал		20,000.00	-
35	Шагнал урамшуулал	3,612.00	8,700.00	19,024.00
36	Буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэлэг	5,190.00	12,450.00	12,900.20
37	Нийтийн эрүүл мэндийг хамгаалах, сургалт уулзалтын зардал	16,003.80	12,600.00	14,084.90
38	Хүүхдийн бэлэг	4,924.50	6,300.00	6,462.30
39	Өндөр настанд хүндэтгэл үзүүлэх зардал	7,753.60	12,000.00	9,853.00

40	Тэтгэвэрт гарахад нэг удаагийн тэтгэмж	5,600.00	90,357.60	62,548.00
41	Дотоод, гадаад уулзалт зөвлөгөөны зардал	-	25,000.00	-
42	Зөвлөх үйлчилгээний зардал	2,625.00	-	-
43	Бусад зардал	2,418.00	9,000.00	2,942.10
44	Баруун бүсийн НААҮ-ний ажилчдын ажил мэргэжлийн уулзалт	18,425.00	18,000.00	12,600.00
45	Ажилчдыг идэвхжүүлэх үйл ажиллагааны зардал /спортын арга хэмжээ, заалны түрээс/	-	4,564.00	4,956.40
46	Актаар	15,540.90	-	-
47	Байр хоол	9,327.60	-	-
48	Торгууль нөхөн татвар	740.10	-	1,080.00
49	Орлогын урамшуулал /жолооч/	16,010.70	15,000.00	15,404.90
50	Түрээсийн зардал	3,150.00	-	-
51	ус ашиглах дүгнэлт	376.00	-	-
52	Тусгай зөвшөөрлийн нэмэлт	1,900.00	-	-
53	Зохиогчийн хяналтын зардал		-	10,000.00
	Задлын дүн	2,455,547.90	3,351,402.93	3,125,245.74
	Орлого	2,336,974.60	2,821,930.00	2,865,558.30
	Ашиг алдагдал	(118,573.30)	(529,472.93)	(259,687.44)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компанийн үйл ажиллагаа

“Чандмань- Увс” ХХК нь Улаангом сумын айл өрх, аж ахуйн нэгжийг стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангах, экологийн тэнцвэрт нийцсэн бохирыг байгальд нийлүүлэх, усан хангамж, ариутгах татуурга, нийтийн халуун усаар үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

“Чандмань-Увс” ХХК нь 1951 онд “Иргэдэд үйлчлэх товчоо” нэртэйгээр үүсгэн байгуулагдан аймгийн төвийн усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээ, нам даралтын уурын зуухны халаалт, орон сууцны хог тээвэр, цэвэрлэгээ зэрэг үйл ажиллагааг явуулж ирсэн бөгөөд 1971 онд Нийтийн аж ахуйн үйлчилгээний яам байгуулагдсанаар үйлчилгээний хүрээ өсөн нэмэгдэж Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар нэртэйгээр анх байгуулагдсан байна.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар дотроо Нийтийн аж ахуй, Ахуйн үйлчилгээ, Барилга засвар гэсэн 3 салбартай томоохон байгууллага болтлоо өссөн ба 1990-ээд оноос улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, Ахуйн үйлчилгээний салбар хувьчлагдаж Нийтийн аж ахуйн салбар төрийн өмчийн байгууллага болон үлдэж 1992 онд Аймгийн Ардын депутатын хурлын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр татан буулгаж, аймгийн Ус сувгийн газар байгуулагдсанаар Улаангом хотын цэвэр бохир усны инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, гэр хорооллын айл өрхүүдийн усан хангамж, нийтийн халуун усны үйлчилгээ тус байгууллага хариуцан ажиллаж ирсэн.

Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч агентлаг Нийтийн аж ахуйн үйлчилгээний газрын даргын 1999 оны 06 сарын 17-ны өдрийн А/14 тоот тушаалаар Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудыг Монгол Улсын “ Нөхөрлөл компанийн тухай” хуулийн

дагуу компанийн хэлбэрээр зохион байгуулж, удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэж 1999 оны 9 сараас Увс аймгийн Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань-Увс" ХХК болгон өөрчлөн зохион байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

"Чандмань-Увс" ТӨХК-ийн хувьд дараах хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

"Чандмань-Увс" ХХК-ийн дотоод хяналт, аудит нь тайлант онд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Захирлын 2024,2 025 оны "А", "Б" тушаалд хяналт шалгалт хийх,
- Албан тушаалын тодорхойлолт болон хувийн хэрэгт хяналт хийх,
- Халуун усны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх,
- Орон сууц хариуцсан борлуулалтын ажилтан нарын ажлыг шалгах зэрэг ажлыг төлөвлөн гүйцэтгэж хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг засах сайжруулах зөвлөмж чиглэл өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудиторын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус компани нь 2020 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд үйл ажиллагааны онцлогт нь тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

"Чандмань-Увс" ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт дагуу бэлтгэсэн байна.

"Чандмань-Увс" ХХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,714,503.2 мянган төгрөгөөр буюу 19 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	363,923.2	301,435.8	-62,487.4
Авлага	79,690.6	177,008.6	97,318.0
Бараа материал	150,000.6	160,183.1	10,182.5
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	30,600.0	1,000.0	29,600.0
Үндсэн хөрөнгө	6,749,122.1	8,456,301.2	1,707,179.1
Нийт хөрөнгө	9,014,705.0	10,729,208.2	1,714,503.2
Өр төлбөр	945,796.2	978,368.2	32,572.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,635,334.3	1,635,334.3	0.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,014,705.0	10,729,208.2	1,714,503.2

Оны эхнээс мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 62,487.4 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд харилцах данс 300,144.4 мянга, касс 1,291.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 177,008.6 мянган төгрөг болж 97,318.0 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагуудаас авах авлага 83,447.8, албан хаагчдаас авах авлага 16,154.4 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Бараа материалын үлдэгдэл 6.7 хувь буюу 10,182.5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байгаа нь тайлант онд 413,458.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 403,276.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Урьдчилж төлсөн зардал тооцоо дансны үлдэгдэлд 1,000.0 мянган төгрөг байгаа нь Увс аймгийн 100 жилийн ойн хүрээнд зарлагдсан тендер шалгаруултанд оролцох барьцаа хөрөнгийг голомт банкны дансанд байршуулсаныг урьдчилж төлсөн зардал, тооцоо дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 25.2 хувиар буюу 1,707,179.1 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр худалдан авсан 97,445.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 195,944.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 12,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1,964.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй хүлээн авсан 275,212.8 мянган төгрөгийн барилга байгууламж, 1,666,405.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, 4,600.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг бусад байгууллагад шилжүүлсэн, 69,247.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данс бүртгэлээс хассан, элэгдлийн зардал 535,294.0 мянган төгрөгөөр байгуулсантай холбоотой үндсэн хөрөнгийн үлдэгдэл өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 3.4 хувиар буюу 32,572.0 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх халаалтын өр төлбөр өссөнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 19.0 хувиар буюу 1,714,503.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд бусад эх үүсвэрээс хүлээн авсан үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Чандмань-Увс” ХХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр тогтоолоор “Чандмань-Увс” ХХК-ийн 2025 оны бизнес төлөвлөгөөний нийт орлогыг 2,821,930.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг

3,351,402.8 мянган төгрөгөөр, 529,472.9 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 2,865,558.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,134,935.7 мянган төгрөгийн зардал гарган, 259,687.4 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,865,558.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 43,628.3 мянган төгрөг буюу 1.5 хувиар давсан биелэлттэй байна. Энэ нь тайлант онд 384 айл өрх, 20 аж ахуйн нэгж байгууллага нэмэгдсэн, төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагын тариф нэмэгдсэн, дуудлага, хөлдөлт, засвар үйлчилгээний орлого өссөнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 3,125,245.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 226,157.2 мянган төгрөг буюу 6.7 хувиар хэмнэсэн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд 259,687.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь төлөвлөснөөс 269,785.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	27,306.0	Тайлант онд Санхүүгийн СИ ТЭ ЭС программ 3,000.0 мянган төгрөгөөр худалдан авч ашиглаж эхэлсэн байна.
2	Унаа, хоолны зардал	100,040.5	хоолны зардал өдрийн 8.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар	10,175.0	Бүх ажилчид ХАБЭА сургаалтанд хамрагдсан мөн МНААХ, ХСУХАТАҮЗ Хорооноос зохион байгуулсан хүн сургалтад 11 хүн хамрагдсан
4	Гадаад томилолт, арга хэмжээ	5,100.4	Цэвэрлэх байгууламжийн сургалтад Польш улсад 2 албан хаагч хамрагдсан
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	5,350.0	Орон нутгийн 2 телевиз болон Увсын өнгө сонинтой хамтран ажиллаж байна.
7	Орон тоо	1,506,061.5	Тайлант онд 63 орон тоо ажиллахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 61 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.5.1 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

“Чандмань-Увс” ХХК нь 2025 онд харьцуулалтын аргаар 1, шууд худалдан авалт 16 нийт 17 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:

Д/д	Нэр төрөл	Төсөвт өртөг	Худалдан авах ажиллагааны төрөл
1	1-р өргөгч станцын гадна хашааг шинэчлэх, засварлах	16,300.00	ШХА
2	Цэвэр усны 1-р эх үүсвэрийн өргөгч насосны станцын автоматжуулалт	12,353.00	ШХА
3	Цэвэр усны 1-р эх үүсвэрийн 1,2-р худгийн автоматжуулалт	16,346.00	ШХА
4	Цэвэр усны 1-р эх үүсвэрийн 3,4-р худгийн автоматжуулалт	16,346.00	ШХА

5	Цэвэр усны 2-р эх үүсвэрийн өргөгч насосны станцын автоматжуулалт	12,353.00	ШХА
6	Цэвэр усны 2-р эх үүсвэрийн 1,2-р худгийн автоматжуулалт	16,346.00	ШХА
7	Цэвэр усны 2-р эх үүсвэрийн 3,4-р худгийн автоматжуулалт	16,346.00	ШХА
8	Цэвэр усны 1-р эх үүсвэрийн өргөгч насосны станцад цахилгаан соронзон тоолуур тавих	11,000.00	ШХА
9	Цэвэр усны 1-р эх үүсвэрийн гүний худгуудад цахилгаан соронзон тоолуур тавих /ф80/	11,800.00	ШХА
10	Цэвэр усны 2-р эх үүсвэрийн өргөгч насосны станцад цахилгаан соронзон тоолуур тавих	7,700.00	ШХА
11	Цэвэр усны 2-р эх үүсвэрийн гүний худгуудад цахилгаан соронзон тоолуур тавих /ф100/	12,760.00	ШХА
12	Цэвэр усны гүний худгуудад нөөцийн 11-13 квт 50-71 м түрэлттэй , 60-90 м3 хүчийн чадал бүхий насос авах /	16,500.00	ШХА
13	Конторын албан хэрэгцээний компьютерийн шинэчлэл хийх	6,900.00	ШХА
14	Авто гражын хана шинэчлэх өргөтгөх	18,000.00	ШХА
15	Авто гражын дээвэр шинэчлэлт, өргөтгөлт	19,000.00	ШХА
16	Авто гражын хаалга шинэчлэх, шал засварлах	13,000.00	ШХА
17	Бензин, шатахуун	65,462.00	ХА
	Дүн	288,512.00	

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Чандмань-Увс” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “Чандмань-Увс” ХХК-ийн орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын өртгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт борлуулалтын өртөг 1,993,127.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 19,931.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын өртөг 2,411,762.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 24,117.6 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 19,294.1 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Чандмань-Увс” ХХК нь захирлын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/46 дугаар тушаалаар компанийн шинэ жилийн баярын цэнгүүний үйл ажиллагаанд зориулан 6,785.0 мянган төгрөг, 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр цэвэрлэх байгууламжийн Улаанбаатар хотоос ирсэн хүмүүст зориулж согтууруулах ундаа худалдан авахад 340.0 мянган төгрөг, захирлын 2025 оны А/07, А/11, А/17, А/44 дүгээр тушаалуудаар тэмцээн уралдаан болон ажилчдын хүүхдүүдэд шинэ жилээр бэлэг өгөхөд компанийн төсвөөс 6,197.8 мянган төгрөгийг компанийн төсвөөс зарцуулсан байна

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь заалтад “Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.1.7 дахь заалтад “Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах”, 15.1.8 дахь заалтад “Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасныг тус тус зөрчсөнд 1 акт тогтоож, 1 албан шаардлага өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Чандмань-Увс” ХХК нь шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 575,885.4 мянган төгрөгийн 44 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 132,900.1 мянган төгрөгийн 45 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 811,327.6 мянган төгрөгийн 52 зарлагын мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроон байршуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрлээ. Үүнд :

1. “Чандмань-Увс” ХХК нь 2025 онд нэг албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэл бодогдох дүнг нийгмийн даатгалын тайлангаар 10,940.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна”, 19.1.1 дэх заалтад “Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор”, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт “Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ”, 32.2.2 дахь заалтад “Орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” гэж заасанд нийцэхгүй байгаа тул аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.
2. Тайлант онд “Чандмань-Увс” ХХК нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг “Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно”, 119.1.4 дэх заалтад “Хууль тогтоомжид заасан бусад тохиолдол” гэж заасныг зөрчин албан хаагчдын цалин хөлснөөс хуульд заагаагүй хувь хүний цэвэр бохир усны төлбөр 2,803.2 мянга, гар утасны ярианы төлбөр 6,092.0 мянга, нийт 8,895.2 мянган төгрөгийн суутгал хийсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Чандмань-Увс” ХХК -ийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цалин хөлснөөс хуульд заагдаагүй суутгал суутгасан эсэхийг анхаарах.
2. “Чандмань-Увс” ХХК албан томилолтын олговор олгохдоо томилолтын хуудсанд ирсэн, явсан өдрийг тэмдэглээгүй, эрх бүхий албан тушаалтан хэдэн хоногоор, хэдэн хувиар олгохыг тэмдэглээгүй зэрэг зөрчлийг аудитын явцад залруулсан, дараагийн аудитаар албан томилолтын зардлыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,558,090.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 7,935.0 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 6,197.8 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,520,113.1 мянган төгрөгийн зөрчил 1 албан шаардлага, 23,845.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт-1

“Чандмань-Увс” ХХК нь захирлын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/46 дугаар тушаалаар компанийн шинэ жилийн баярын цэнгүүний үйл ажиллагаанд зориулан 6,785.0 мянга, 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр цэвэрлэх байгууламжийн Улаанбаатар хотоос ирсэн хүмүүст зориулж согтууруулах ундаа худалдан авахад 340.0 мянга, нийт 7,125.0 мянган төгрөгийг компанийн төсвөөс зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь заалтад “Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.7 дахь заалтад “Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах”, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын 1.3-д “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж, төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн төсвөөс хуулиар хориглосон зардал буюу шинэ жилийн арга хэмжээ, согтууруулах ундаанд зарцуулсан 7,125.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Төлбөрийн акт-2

“Чандмань-Увс” ХХК нь захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар нэг албан хаагчид ногдуулсан сахилгын шийтгэл 810.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэгт “Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно”, 119.1.3 дахь заалтад “Ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлийн суутгал 810.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага-1

“Чандмань-Увс” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/07, А/11, А/17, А/44 дүгээр тушаалуудаар тэмцээн уралдаан болон шинэ жилийн бэлэг өгөхөд компанийн төсвөөс 6,197.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь заалтад “Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.1.8 дахь заалтад “Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өглөө.

Албан шаардлага-2

“Чандмань-Увс” ХХК нь шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 575,885.4 мянган төгрөгийн 44 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 132,900.1 мянган төгрөгийн 45 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 811,327.6 мянган төгрөгийн 52 зарлагын мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь заалтад “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж-1

Зардлын данстай холбоотой

5.3.1 Илрүүлэлт:

“Чандмань-Увс” ХХК 2025 онд 16 ажилтанд олгосон 23,845.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг тайлант хугацаанд суутган тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

5.3.2 Өгсөн зөвлөмж:

Суутган тооцоогүй 23,845.0 мянган төгрөгийн цалингийн авлагыг барагдуулах, цалингийн урьдчилгааг тухай бүр суутган тооцох.

дүгээр тушаалаар нэг албан хаагчид ногдуулсан сахилгын шийтгэл 810.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй зөрчил илэрлээ.											
"Чандмань-Увс" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/07, А/11, А/17, А/44 дүгээр тушаалуудаар тэмцээн уралдаан болон ажилчдын хүүхдүүдэд шинэ жилээр бэлэг өгөхөд компанийн төсвөөс 6,197.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.					1	6,197.8					
"Чандмань-Увс" ХХК 2025 онд 16 ажилтанд олгосон 23,845.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг тайлант хугацаанд суутган тооцоогүй байна.							1	23,845.0			
Дүн	4	37,977.8	2	7,935.0	1	6,197.8	1	23,845.0			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	1	1,520,113.1					1	1,520,113.1
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хууль тогтоомж зөрчсөн								
Дүн								
Нийт дүн	1	1,520,113.1					1	1,520,113.1

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.АМАРМЭНД/

2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 01/22/А2070413
УВН-2026/002/НВ-СТН-01ӨҮГ

Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэргээ.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК нь захирлын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/46 дугаар тушаалаар компанийн шинэ жилийн баярын цэнгүүний үйл ажиллагаанд зориулан 6,785,000 төгрөг, 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр цэвэрлэх байгууламжийн Улаанбаатар хотоос ирсэн хүмүүст зориулж согтууруулах ундаа худалдан авахад 340,000 төгрөг, нийт 7,125,000 төгрөгийг компанийн төсвөөс зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь заалтад “Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.7 дахь заалтад “Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах”, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын 1.3-д “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж, төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх,

төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8 дахь заалтад "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн төсвөөс шинэ жилийн баярын цэнгүүний зардал, согтууруулах ундаа худалдан авахад зарцуулсан 7,125,000 /Долоон сая нэг зуун хорин таван мянга/ төгрөгийг Ув.МХГ-ын орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань-Увс" ХХК-ийн захирал Б.Алтангэрэл, нягтлан бодогч Ц.Эрдэнэбат нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР



Т.АМАРМЭНД

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 02/23/ АА070413
УВА-2026/002/НА-СТН-ДНӨҮГ

Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэргээ.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК нь захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар нэг албан хаагчид ногдуулсан сахилгын шийтгэл 810.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэгт “Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно”, 119.1.3 дахь заалтад “Ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3 дахь заалтад “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сахилгын шийтгэлийн суутгал 810,000 /найман зуун арван мянга/ төгрөгийг МХГ-ын орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК-ийн захирал Б.Алтангэрэл, нягтлан бодогч Ц.Эрдэнэбат нарт хариуцуулав.

3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР



Т.АМАРМЭНД

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 01/46/А.2070413
УБД - 2026/092/НА-СТА-01091

Улаангом

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань-Увс" ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань-Увс" ХХК-ийн захирлын 2025 оны А/07, А/11, А/17, А/44 дүгээр тушаалуудаар тэмцээн уралдаан болон шинэ жилийн бэлэг өгөхөд компанийн төсвөөс 6,197.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна", 3.1.3 дахь заалтад "Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан", 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5 дахь заалтад "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.8 дахь заалтад "Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийн таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасныг мөрдөн ажиллаж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар² т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань-Увс" ХХК-ийн захирал Б.Алтангэрэл, нягтлан бодогч Ц.Эрдэнэбат нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР



Т.АМАРМЭНД

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 02/47/А2070413
УВА-2026/002/НА-СТА-010217

Улаангом

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК нь шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 575,885.4 мянган төгрөгийн 44 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 132,900.1 мянган төгрөгийн 45 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 811,327.6 мянган төгрөгийн 52 зарлагын мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь заалтад “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийн таслан зогсоож, давтан гаргахгүй байх

үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн
ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасныг мөрдөн ажиллаж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар² т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК-ийн захирал Б.Алтангэрэл, эдийн засагч Б.Хандсүрэн нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Т.АМАРМЭНД

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ

